





9.1г. “Хүний эрхийн булан”-д илэрхийлсэн эрхүүдийг дараах эрхүүдийн төрөлд ангилан бичнэ үү. Хүний эрхийг ангилах хэрэгцээ, төрлийн талаар өөрийн үзэл бодлоо бичээрэй.

1	Иргэний эрх	<b>Хүний эрхийг ангилах хэрэгцээ ба төрөл:</b>
2	Улс төрийн эрх	
3	Эдийн засгийн эрх	
4	Соёлын эрх	
5	Нийгмийн эрх	

9.1д. Дараах зургийг ажиглан хүний эрхийг хамгаалах эрх зүйн баримт бичиг болон байгууллагуудыг сонгож, даалгаврыг алхамын дагуу гүйцэтгээрэй.



**Алхам-1:** Хүний эрхийг хамгаалах эрх зүйн баримт бичиг болон байгууллагуудын дугаарыг өгөгдсөн хүснэгтэд тэмдэглэнэ үү.

**Алхам-2:** Хүний эрхийг хамгаалах эрх зүйн баримт бичиг болон байгууллагуудаас нэг, нэгийг сонгон хүний эрхийг хамгаалах чиг үүрэг ба ач холбогдолыг тайлбарлан бичээрэй.



<b>Алхам-1</b>	Эрх зүйн баримт бичиг:	Хүний эрхийг хамгаалах байгууллагууд:
<b>Алхам-2</b>		

**Өөрийгөө үнэлээрэй:** 2 од хэсэгт гүйцэтгэсэн даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадсанаа, 1 хүсэл хэсэгт ойлгоогүй, эргэлзсэн, дэмжлэг шаардлагатай даалгаврыг тус тус бичнэ үү.

 <b>2 од</b>	 <b>1 хүсэл</b>	 <b>Багшийн тэмдэглэл</b>

Бүлэг сэдэв: **ХҮНИЙ ЭРХ БА ХУУЛЬ**  
 Сурагчийн овог, нэр:.....



**9.2а. Даалгаврыг алхамын дагуу гүйцэтгээрэй.**

1. Дараах ойлголтуудыг тохирох тодорхойлолт бүрд нөхөн бичнэ үү.
2. Нөхөж гүйцээсэн тодорхойлолтыг тохирох хуулийн заалттай холбоно уу.

**Үзэл бодлоо илэрхийлэх эрх**

**төрийн үүрэг**


**хяналт тавих, шүүмжлэл өрнүүлэх**

**хүний эрхийн зөрчил**

**Нэг цонхны үйлчилгээ**

<p>1. Хүнийг эрхээ эдлэхэд нь саад учруулахгүй байх, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх нь..... юм.</p>	<p>А. Үзэл бодлоо саадгүй баримтлах, үзэл санаа мэдээллийг хилийн зааг үл хязгаарлан эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.  <b>(ХЭТТ-ын 19 дүгээр зүйл)</b></p>
<p>2. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь мэдээлэл олгох, иргэдийн санаа бодол төлөвшүүлэхэд туслах, цэнгээн баясгах-боловсрол олгох, ..... зэрэг үүрэгтэй.</p>	<p>Б. Хууль эрх зүйн баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.  <b>(МУ-ын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйл)</b></p>
<p>3.....нь үг хэлэх, хэвлэн нийтлэх, урлаг, уран сайхнаар илэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх гэх мэт арга хэлбэрүүдтэй.</p>	<p>В. 3.1.2. Эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас сэргийлэх.</p>
<p>4..... нь төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилготой.</p>	<p>Г. ТҮЦ машин, 1111 засгийн газрын утас, иргэд хүлээн авах танхим зэрэг үйлчилгээ нэмэгдсээр байна.</p>
<p>5. Хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх үйл явцыг..... гэнэ.</p>	<p>Д. Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.</p>

9.26. Дараах ойлголтуудын тодорхойлолтыг бичээрэй.  
(сурах бичгийн 64 дэх тал)



9.2в. Дараах хүснэгтэд хуульчилсан актын төрөл ба батлан гаргах субъектийг зөв нэрлэж, нөхөн бичнэ үү. (сурах бичгийн 65 дахь тал. хүснэгт 2.1)

Хуульчилсан акт		Батлан гаргах субъектийн нэр
1	Тогтоол	
2		Ерөнхийлөгч
3	Тушаал	
4		Аймаг, нийслэлийн Засаг дарга
5	Шийдвэр	

9.2г. 1. МУ-ын Үндсэн хуулийн заалтыг анхааралтай уншиж, тухайн заалт нь өгөгдсөн үүргүүдийн алинд нь хамаарахыг  тэмдгээр тэмдэглэнэ үү. (сурах бичгийн 67 дахь тал)

**“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”**  
(Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйл)

- Хүний эрхийг хамгаалах Үндсэн хуулийн үүрэг
- Хүний эрхийг хамгаалах төрийн үүрэг
- Хүний эрхийг хамгаалах эдийн засгийн үүрэг
- Хүний эрхийг хамгаалах төрийн бус байгууллагын үүрэг

2. Төр иргэнийхээ өмнө ямар, ямар чиглэлийн үүрэг хүлээн хариуцдагийг Үндсэн хуулийн тухайн заалтыг үндэслэн тодорхойлоорой.

- а.....
- б.....
- в.....

**9.2д.** 1. Монгол Улсын Үндсэн хуулийн 2-р бүлэгт хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулан заахын хамт иргэний ёсчлон биелүүлэх үндсэн үүргийг тодорхойлон заасан. Үндсэн хуулинд заасан МУ-ын иргэний үүргүүдийг зөв нөхөн бичээрэй. (Үндсэн хуулийн 2-р бүлэг 17 дугаар зүйл)

1. Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх

2. ....

3. Хуулиар ногдуулсан албан татвар төлөх

4. ....


5. Хөдөлмөрлөх




6. ....

7. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх

8. ....

2. Монгол улсын иргэний үүргийг үндсэн ба журамт гэж ангилдаг. Дээрх иргэний үүрэг аль ангилалд хамаарахыг ялган бичээрэй. (Зөрчигдсэн эрхээ хэрхэн хамгаалуулах вэ? теле хичээлийг үзээрэй)



<p><b>Өөрийгөө үнэлээрэй:</b> Гүйцэтгэсэн даалгаврын дугаарыг би хийж дууссан, би эргэлзэж байна, тусламж хэрэгтэй гэсэн хэсгүүдэд тэмдэглэнэ үү.</p>			
 <p>Би хийж дууссан</p>	 <p>Би эргэлзэж байна</p>	 <p>Надад тусламж хэрэгтэй байна</p>	 <p>Багшийн үнэлгээ</p>

**9.3а.** Даалгаврыг алхамын дагуу гүйцэтгэнэ үү. (Хүний эрхийг хэрхэн ангилдаг вэ? теле хичээлээ үзээрэй. Сурах бичгийн 63 дахь тал)

**Алхам 1:** Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрхүүдийг хүний эрхийн ангиллын холбогдох хэсэгт зөв нөхөж, дугаараар нь тэмдэглээрэй.

**Алхам 2:** Иргэний үндсэн эрхүүд нь олон улсын эрх зүйн аль пактад хамаарахыг ялган бичнэ үү.

Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрхүүд	Хүний эрхийн ангилал	Хүний эрхийн тухай олон улсын ПАКТ
1. Сурч боловсрох 2. Хөдөлмөрлөх 3. Үзэл бодлоо илэрхийлэх 4. Сонгох, сонгогдох 5. Бүтээл туурвих 6. Өв залгамжлах 7. Эрүүл мэндээ хамгаалах 8. Шашин шүтэх, эс шүтэх 9. Амьд явах 10. Халдашгүй, чөлөөтэй байх	Эдийн засгийн эрх: .....	<b>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт:</b> ..... ..... .....
	Улс төрийн эрх: .....	
	Соёлын эрх: .....	<b>Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт:</b> ..... ..... .....
	Нийгмийн эрх: .....	
	Иргэний эрх: .....	.....

**9.3б.** Хуулийн заалт болон хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх зарчим, ХЭТТ-ын заалтыг уншиж, эдгээрийн ижил ба ялгаатай талыг харьцуулан тодорхойлно уу.

Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. <b>(МУ-ын Үндсэн хуулийн 14-р зүйл)</b>	Ижил тал:  Ялгаатай тал:	Хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх зарчим: ✓ Хүн бүр хууль ёсыг сахих ✓ Хууль бүх хүнд адил тэгш үйлчлэх ✓ Шударга шүүхээр шүүлгэх гэх зэрэг. <b>(СБ-ийн 66 дахь тал)</b>
Ижил тал: ..... ..... ..... .....	Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. <b>(ХЭТТ-ын 1-р зүйл)</b>	Ялгаатай тал: ..... ..... ..... .....

**9.3в.** Нэг цонхны үйлчилгээний талаарх судалгааг шинжлээрэй.

Судалгаанд оролцсон 3 хүн тутмын 2 хүн буюу 66% НЦҮ-нд хамрагдаж , нэг хүн буюу 34% нь хамрагдаагүй байна. “НЦҮ-ээр дамжуулан мэдээлэл авах бололцоо” талаарх асуултад хариулж мэдэхгүй байна-13%, чадсан-46%, сайжруулах шаардлагатай-33%, мэдээлэл авах бололцоо бүрдээгүй-8% гэж хариулжээ. “НЦҮ-ий аль төрөлд сэтгэл ханамжтай байна вэ?” асуултад иргэний бүртгэл-24%, хөдөлмөр нийгмийн халамж-22%, эд хөрөнгийн бүртгэл-21%, нийгмийн даатгал-15%, газрын харилцаа-8%, иргэний өргөдөл гомдол-10% гэж хариулжээ. Судалгаанд оролцсон нийт иргэний 90% нь төрийн захиргааны байгууллагын үйлчилгээг иргэдэд ойр болсон гэж үзжээ.

- Судалгаан дахь 3 төрлийн тоон мэдээллийг тус тус графикаар дүрсэлнэ үү. График бүрийнхээ утгыг тайлбарлан бичээрэй.



- Нэг цонхны үйлчилгээний төрлүүдийг нэмж бичнэ үү. (СБ-ийн 69 дахь тал. бүдүүвч 3.2)

- НЦҮ-ээс өөр иргэдэд чиглэсэн ямар үйлчилгээ байдаг вэ?

- Төрийн захиргааны байгууллагын үндсэн чиг үүргийг тодорхойлно уу. (СБ-ийн 67-68 дахь тал)

- Төрийн захиргааны байгууллага нь иргэний ямар эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах талаар үйл ажиллагаа явуулдагийг тодорхойлно уу.






**9.3г.** Хүний эрхийн зөрчилтэй холбоотой тохиолдлыг шинжлээрэй.  
(Зөрчигдсэн эрхээ хэрхэн хамгаалуулах вэ? теле хичээлийг үзээрэй)

ТОХИОЛДОЛ	ЯМАР ЭРХ ХЭРХЭН ЗӨРЧИГДСЭН БЭ?	ЭРХИЙГ ХАМГААЛАХЫН ТУЛД ЮУ ХИЙВЭЛ ЗОХИСТОЙ ВЭ?
Дэлгүүр, үйлчилгээний төв болон төрийн байгууллагуудад налуу зам байхгүй тул тэргэнцэртэй иргэд ороход хүндрэлтэй байдаг.		
БЗД-ийн нэгэн хороонд “М” компани нь 2020 онд нийслэлийн <b>засаг даргын захирамжаар</b> газар эзэмшин, 2021 онд айлын хашаанд тулган, мөн орон сууц, ЕБС-тай 10 метр зайтай ШТС-ыг барьсан нь иргэдийг бухимдуулж байна.		
Үе тэнгийн хүүхдүүд нэгэндээ нэр хоч өгөх, элдвээр доог тохуу хийх нь сургуулиас завсардах хүртэл сөрөг нөлөөтэй.		
Аймаг, сумын төвд нийтэд зориулсан бие засах газар, хогийн сав хангалтгүй тул орчны бохирдол, хог хаягдал улам бүр нэмэгдсээр байна.		

**ТУХАЙН БҮЛГЭЭР ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ЭЗЭМШСЭН МЭДЛЭГ, ХАНДЛАГАА ДҮГНЭН ЦЭГЦЭЛЖ, АНГИДАА “ХҮНИЙ ЭРХИЙН БУЛАН” БҮТЭЭГЭЭРЭЙ.**

**Өөрийгөө үнэлээрэй:** Сайн гүйцэтгэсэн даалгаврын дугаарыг “бие дааж хийсэн” хэсэгт, сурах бичиг, теле хичээл үзэж судлаад хийсэн даалгаврын дугаарыг “уншиж судлаад дахин хийсэн” хэсэгт, эргэлзээтэй, ойлгомжгүй, чадаагүй даалгаврын дугаарыг “багшийн тусламж хэрэгтэй” гэсэн хэсэгт тэмдэглэнэ үү.

 Бие дааж хийсэн	 Уншиж судлаад дахин хийсэн	 Багшийн тусламж хэрэгтэй	 Багшийн дэмжлэг, чиглүүлэг хэрэгтэй

**9.1а.** Дараах даалгаврыг гүйцэтгэж төр засгийн талаарх мэдлэгээ зааврын дагуу ерөөний халуун хэмжигчид тэмдэглэж үнэлээрэй. Зөв хийсэн даалгаврын дугаарыг хэмжигч дээрх дугаараас дугуйлна. Эргэлзээтэй даалгаврыг дугаарын харалдаа байгаа тэгийг будна. Эргэлзэж байгаа даалгавраа багшаасаа асууж мэдлэгээ бататгаарай.

1. Чиний бодлоор Монгол улс улс төрийн аль дэглэмд хамаарах вэ?

2. Монгол улсын иргэдийн нийтээр дагаж мөрдөх хуулийг батлах эрх мэдэл хэнд байдаг вэ?

3. Төр засгийн бүх нийтийг захирах эрх мэдэл юунаас эхлэлтэй вэ?

4. Иргэд үзэл бодлоо төр засагт хүргүүлэх, оролцох ямар боломж байдаг вэ? бичээрэй.



- Ардчилсан
- Тоталитар
- Ардчилсан бус
- Авторитар

- Төр засаг
- УИХ
- Ард иргэд
- Засгийн газар

- Төр засгийн шийдвэр
- Ард иргэдийн сонголт
- Захирах, захирагдах ёс
- Сонгох, сонгогдох эрх

<b>9.1б.</b>		
<b>1. Дараах ойлголтууд нь ардчилсан ба ардчилсан бус дэглэмийн алинд нь хамаарахыг зөв тэмдэглээрэй.</b>	<b>Ардчилсан</b>	<b>Ардчилсан бус</b>
Ард түмэн сонгуулиар хууль тогтоох байгууллагаа (парламент) бүрдүүлдэг. Хууль тогтоогчид хуулийн төсөл боловсруулж иргэдээс санал авч хууль баталдаг.		
Нэгэн улсад хувьсгал гарч, армийн генерал Ерөнхийлөгч болжээ. Ерөнхийлөгч хууль гаргаж, шүүгчдийг болон бусад төрийн албаны хүмүүсийг томиллоо.		
Нэг буюу цөөн тооны хүн засгийн эрхийг барьдаг.		
Төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх байгууллагад хуваарилдаг.		
<b>2. Ардчилсан дэглэм дэх иргэн, төрийн харилцааны талаар өөрийн санаа бодлыг илэрхийлнэ үү.</b>		

**9.2a.** Монгол улсын Үндсэн хуулийн заалтыг уншаад төрийн эрх мэдлийг хэрхэн хуваарилсныг бүдүүвчээр илэрхийлнэ үү. (СБ-ийн 82 дахь тал. 1992 оны Үндсэн хуулийн “ Монгол улсын төрийн байгуулал” 3-р бүлэг. //legalinfo.mn/)

- Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална. (Үндсэн хуулийн 20 дугаар зүйл)
- Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна. (Үндсэн хуулийн 41.1 дүгээр зүйл)
- Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. (Үндсэн хуулийн 47.1 дүгээр зүйл)



**9.2б.** Сараад тохиолдсон асуудлыг хэлэлцье. (улс төрийн дэглэм дэх иргэдийн оролцоо ямар ач холбогдолтой вэ? теле хичээлээ үзээрэй)

Сараа шинэ газар нүүж ирэхэд хүүхдээ өгөх цэцэрлэг байхгүй байсан нь ажлаа хийхэд хүндрэл учрав. Сараа шинэ хорооны иргэдтэй уулзан өөртэй нь адилхан асуудал тулгарсан хүмүүстэй нэг баг болон хороондоо хүүхдийн цэцэрлэгтэй болох санал, шаардлагыг хорооны иргэдтэй харилцах цахим хуудсанд бичих, ИТХ-ын төлөөлөгчтэй биечлэн уулзах, тойргоос сонгогдсон гишүүнд захидал бичих зэргээр хүргүүлжээ. Хэдэн сарын дараа иргэдийн идэвх оролцоо, санал санаачилага бодитой хэрэгжин ИТХ-аас тус хороонд 120 хүүхдийн цэцэрлэг барих төсөл батлагджээ.


1. Сараад тулгамдсан асуудал юу байсан бэ?

2. Ямар алхамуудаар ажилласан бэ?

3. Төр засгийн үйл ажиллагаанд иргэдийн оролцох ямар боломжууд байна вэ?

4. Ямар үр дүнд хүрсэн бэ?

9. 2в. Хууль бүтээх үйл ажиллагааны дарааллыг гүйцээж, онцлогийг тайлбарлана уу. (СБ-ийн 84 дэх тал. бүдүүвч 2.1)







9.2г. Дараах өгөгдлийг уншаад иргэдийн оролцооны хэлбэрүүдийн аль нь нийцтэй, аль нь нийцгүйг ялган тэмдэглээрэй. (СБ-ийн 91 дэх тал. улс төрийн дэглэм дэх иргэдийн оролцоо ямар ач холбогдолтой вэ? теле хичээлээ үзээрэй. )

Иргэдийн оролцооны хэлбэр	Нийцтэй оролцоо	Нийцгүй оролцоо
Сонгуульд оролцож саналаа өгөх		
ИТХ-д оролцох		
Өлсгөлөн зарлах, хууль ёсны бус үйлдлүүд		
Тойргоос нэр дэвшсэн гишүүнтэй уулзаж санал бодлоо илэрхийлэх, дамжуулах		
Хэлэлцүүлэг, санал асуулгад оролцох		
Эсэргүүцлийн жагсаал, цуглаан хийх		
Мэдээллийн хэрэгсэлээр үзэл бодлоо илэрхийлэх, захидал бичих		

Нийцтэй оролцооноос нэгийг сонгож, ач холбогдлыг тодорхойлоорой.


**Өөрийгөө үнэлээрэй:** Гүйцэтгэсэн даалгаврын дугаарыг би хийж дууссан, би эргэлзэж байна, надад тусламж хэрэгтэй байна гэсэн хэсэгт тус тус тэмдэглэнэ үү.

 Би хийж дууссан	 Би эргэлзэж байна	 Надад тусламж хэрэгтэй байна	 Багшийн үнэлгээ

Бүлэг сэдэв: **НИЙТИЙН УДИРДЛАГА**  
 Сурагчийн овог нэр:.....

**9.3а. Дараах тохиолдлыг шинжлээрэй.** (засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцох ямар боломж байдаг вэ? теле хичээлээ үзээрэй)

Говийн аймгийн нэгэн суманд засгийн газрын тогтоолоор худаг барьсан ч иргэд худгаа ашиглахын тулд хамгийн багадаа 1км, ихдээ 8 км явж очдог. Худгийг малчдын өвөлжөө рүү шахаж барьснаар тухайн газрын хөрс талхлагдсан. Мөн цаг уурын өөрчлөлтөөс булаг шанд ширгэсэн. Уул уурхайн зохисгүй үйлдвэрлэлээс болж ус хомсдож, бохирдол үүссэн зэрэг нь хүмүүсийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх аюулд хүргэв. Иймд усны нөөцийг нэмэгдүүлэх оновчтой шийдэл бүхий гүний худаг нэмж гаргах, ус ашиглах горимыг хэвшүүлэх, худаг барьсан газраас 5 км газарт бэлчээр, уул уурхайн үйл ажиллагаа явуулахгүй байх саналаа нутгийн иргэд ИТХ, тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүнд захидал бичих, цахим орчинд мэдээллэх зэргээр төр засагт хүргүүлснээр усны тухай шинэчилсэн хуулинд тусгуулж асуудлаа шийдвэрлүүлж чаджээ.

**1. Иргэдэд ямар бэрхшээл тулгарсан бэ?**

**2. Нутгийн иргэд ямар санал дэвшүүлсэн бэ? Өөр ямар оновчтой шийдэл байж болох вэ? дэвшүүлээрэй.**

**3. Төр засагт ямар арга хэлбэрээр асуудлаа хүргүүлсэн бэ? Иргэдийн оролцооны ямар хэлбэрүүд байна вэ? (СБ-ийн 92 дахь тал. хүснэгт 4.2)**

**4. Иргэдийн санал хуулинд хэрхэн нөлөөлсөн бэ? Хуулийг аль байгууллага баталж, хэрхэн хэрэгжүүлж байна вэ?**

**5. Төр засаг, иргэдийн харилцааны талаар үнэлэлт, дүгнэлт өгнө үү.**

**9.36. Хүүхдийн эрхийн тухай хуулийн төсөлд иргэдээс өгсөн саналд дүн шинжилгээ хийцгээе.**

Судалгаанд 359 иргэн оролцсоноос “Хүүхдийн эрхийн тухай болон хүүхэд хамгааллын тухай хуульд санал өгч байсан уу?” гэсэн асуулгад 40 иргэн буюу 11% нь өгч байсан, тэдгээрийн 5 буюу 12,5% нь ямар аргаар санал өгснөө хариулаагүй, 4 буюу 10% нь хэлэлцүүлэгт оролцсон, 6 буюу 15% нь биечлэн уулзсан, 4 буюу 10% нь захидлаар, 7 буюу 17,5% нь утсаар, 5 буюу 12,5 нь и-мэйлээр, 9 буюу 22,5% нь мессежээр тус тус санал өгснөөс 7 иргэн миний саналыг огт тусгаагүй, 8 иргэн саналын заримыг хуулийн төсөлд тусгасан, мөн 5 иргэн миний саналыг хангалттай тусгасан гэж хариулсан бөгөөд 11 иргэн энэ талаар мэдэхгүй байна гэж хариулжээ.

1. Тоон мэдээлэлд үндэслэн:

А. Иргэдийн оролцоо ямар түвшинд байсан бэ?

.....  
.....


Б. Иргэд оролцооны ямар арга хэлбэр ашигласныг графикаар дүрслэн тайлбарлаарай.



2. Тухайн хуулийн төсөлд иргэд саналаа өгөхийн ач холбогдол юу вэ?

.....  
.....  
.....  
.....

3. Хуулийн төсөлд иргэд саналаа өгөх өөр ямар арга зам байх талаар эргэцүүлэмж бичээрэй.



**9.3в.** Нийгэмд тулгамдсан тухайн асуудлыг шийдвэрлэх оновчтой ажиллагаа, саналыг дэвшүүлэн, хэрхэн шийдвэрлэж болох талаар хамтран ажиллая.

Шийдвэрлэх асуудал	Асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй үйл ажиллагаа юу, юу байна вэ?	Тухайн асуудлаар төр засагт хүргүүлэх санал юу байна вэ?
Ус хэмнэх, зохистой хэрэглээг бий болгох		
Агаарын бохирдолыг бууруулах		
Цар тахалыг багасгах, даван туулах		

Өөрийгөө үнэлээрэй: Сайн гүйцэтгэсэн даалгаврын дугаарыг **“бие дааж хийсэн”** хэсэгт, сурах бичиг, теле хичээл үзэж судлаад хийсэн даалгаврын дугаарыг **“уншиж судлаад дахин хийсэн”** хэсэгт , эргэлзээтэй, ойлгомжгүй, чадаагүй даалгаврын дугаарыг **“багшийн тусламж хэрэгтэй”** гэсэн хэсэгт тус тус тэмдэглэнэ үү.

Бие дааж хийсэн	Уншиж судлаад дахин хийсэн	Багшийн тусламж хэрэгтэй	Багшийн дэмжлэг, чиглүүлэг